



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 одор

Дугаар A/31

Улаанбаатар хот

Г Төлөвлөгөө батлах тухай Г


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны салбарт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, мэдээлэл, арга зүйгээр ханганд, хэрэгжилтийн явцыг улирал тутам мэдээлж, тайланг зохих хугацаанд нь эрх бүхий байгууллагад хүргүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/, Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Гантулга/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т тус тус даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



142210670

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн
A/51 тушаалын хавсралт

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хариуцах нэгж, байгууллага	
						Үндсэн	Хамтрагч
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд сууринсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
1.	4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх;	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанад томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.	І-IV улирал		Дүгнэлтүүд ил тод, нээлттэй болсон байна.	ТЗУГ	Төрийн албаны зөвлөлийн БШУЯ-ны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл

		Албан хаагчдын болон харьяа байгууллагын удирдах албан тушаалтны ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь гаргуулан авах арга хэмжээг зохион байгуулна.	I-IV улирал		Хуулийн хугацаанд ХАСУМ, ХАСХОМ-ийг гаргуулах ажлыг зохион байгуулж, холбогдох заавар, зөвлөгөөг өгч ажилласан байна.	ТЗУГ	Төрийн албаны зөвлөлийн БШУЯ-ны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл
2.	4.1.1.2.нийтийн албандаа томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;	Албан тушаалд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албандаа томилох, дэвшүүлнэ.	I-IV улирал		Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг ханган, сул ажлын байр гарсан тухай бүр сонгон шалгаруулалт зарлаж, мерти зарчмыг баримтлан томилон дэвшүүлдэг болсон байна.	ТЗУГ	Төрийн албаны зөвлөлийн БШУЯ-ны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл
		Яамны сул ажлын байр, харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт явуулсан талаарх мэдээллийг олон нийтэд ил тод	I-IV улирал		Хүний нөөцийн ил тод байдлыг хангагдана.	ТЗУГ	Төрийн албаны зөвлөлийн БШУЯ-ны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл

		нээлттэй болгох яамны болон төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулан тухай бүр мэдээллийг шинэчлэн байршуулна.				
3.	4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;	Яамны хүний нөөцийн цогц чадамжийн үнэлгээг хийх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах ажлыг зохион байгуулна.	2, 4-р улирал		Хагас бүтэн жилээр Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлсэн байна. Яамны хүний нөөцийн цогц чадамжийн үнэлгээ хийгдэж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх заавар боловсрогдон үнэлгээнд ашигладаг болсон байна.	ТЗУГ
4.	4.1.1.6.нийтийн албаны ёс зүйн	Яамны ёс зүйн зөвлөлийг	II-II улирал		Яамны ёс зүйн зөвлөл	ТЗУГ ХЭЗХ Яамны ёс зүйн хороо

	<p>үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;</p>	<p>шинэчлэн байгуулж, ёс зүйн зөвлөлийн ажиллах төлөвлөгөө, дүрмийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.</p>			<p>шинэчлэгдэн байгуулагдаж, ёс зүйн зөвлөлийн ажиллах төлөвлөгөө дүрэм батлагдсан байна.</p>		
		<p>Ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтны ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулж холбогдох шийдвэрийг батлуулсан байна.</p>	IV улирал		<p>Ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн зохицуулалт хангагдана.</p>	ЕББЗГ СӨБХ	ХЭЗХ
		<p>Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.</p>	III улирал			ШУТИБХЗГ	ХЭЗХ

5.	4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичиг, зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, судалгаа мэдээллийг заасан хугацаанд хариуг хүргүүлнэ.	I-IV улирал		Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичиг, зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, судалгаа мэдээллийг заасан хугацаанд хариуг хүргүүлж, биелэлтийг гарган тайлагнасан байна. Мөн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдлийн тоо өмнөх оноос буурсан байна.	ТЗУГ	ХЭЗХ
6.	4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах;	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2022-2023 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.	I-IV улирал		Боловсрол, шинжлэх ухааны салбар дахь статистик тоон мэдээллийн үнэн зөв байдал хангагдсан байна.	ЦБСХ	БЕГ
7.	4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулна.	I-IV улирал		Хууль тогтоомжийн хүрээнд хамtran ажилласан байна.	ТЗУГ	АТГ Харьяа байгууллагууд

	боломжийг бүрдүүлэх;						
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
8.	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;	Салбарын үйлчилгээг цахимжуулан иргэд, байгууллагад хүртээмжтэй, түргэн шуурхай ил тод хүргэх боломжийг бий болгоно.	I-IV улирал		E-Mongolia системээр олгож буй Боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн баримт бичгийн лавлагаа болон бусад үйлчилгээний мэдээллийн сан баяжигдсан байна.	ЦБСХ	БЕГ
9.	4.1.2.2. зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх;	Байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг авахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг яамны цахим	I-IV улирал		Боловсрол, шинжлэх ухааны яамнаас чиг үүргийн дагуу олгож буй тусгай зөвшөөрлийн бүртгэл олон нийтэд ил тод нээлтэй болсон байна.	ЦБСХ	БЕГ

		хуудсанд байршуулна.				
10.	4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөөний дагуу харьяа байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулна.	I-IV улирал	Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, хийсэн хяналт шалгалтын дүнг, өгсөн зөвлөгөө зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.	ХШУДАГ	
11.	4.1.2.5.төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах;	Салбарын үйл ажиллагааны болон байгууллагын ил тод байдлыг хангах, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах, албан ёсны цахим хуудсыг хөтлөх, мэдээллээр баяжуулна.	I-IV улирал	Мэдээ, ярилцлага, нийтлэл, нэвтрүүлэг, постер, инфографик хийж мэдээллийн сувгуудаараа түгээж, улирал тутам Хэвлэлийн бага хурал зохион	ТЗУГ	

					байгуулсан байна.		
		Боловсрол, шинжлэх ухааны яамнаас иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээллийн ил тод нээлттэй байх зарчмын дагуу хуульд заасан мэдээ мэдээллийг тухай бүрд цахим сайтад байршуулсан байна.	I-IV улирал		Боловсрол, шинжлэх ухааны яамнаас иргэд, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангагдана. Яамны цахим хуудаснаас мэдээллийг шуурхай авах боломж нөхцөл сайжирсан байна.	TЗУГ	БНБТГ, ШУТБИХХЗГ, ЕББЗГ, ДМББУЗГ, ХШУДАГ, СӨБХ, ХЭЗХ, МТСХ, СХҮҮХ
12.	4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;	Боловсрол, шинжлэх ухааны яаманд хандан иরүүлсэн иргэд байгууллагын өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг яамны 1800-1209, 51-262227 утас, цахим шуудан, факс, бичгээр хүлээн авч хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэн	I-IV улирал		Боловсрол, шинжлэх ухааны яаманд хандан ириүүлсэн иргэд байгууллагын өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэн хариуг хүргүүлсэн байна.	TЗУГ	

		хариуг өгөх ажлыг зохион байгуулна.					
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусlamжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр							
13.	4.1.3.2.төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;	<p>Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийнэ.</p> <p>Төсвийн орлого түүний зарцуулалт, гадаадын зээл, тусlamж түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүрд цахим хуудсаар мэдээлэх арга хэмжээг авч ажиллана.</p> <p>Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний дүн агуулга, хүлээн</p>	I-IV улирал		<p>Холбогдох зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1- 6.1.6-д заасан мэдээллийг заасан хугацааны дотор цахим хуудас болон шийлэн дансанд оруулсан байна.</p> <p>Цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулсан байна.</p>	XШУДАГ	Харьяа байгууллагууд

		авагчийн нэрийг цахим хуудсанд байршуулна.				
		Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлгийг олгох арга хэмжээг ил тод байдлаар зохион байгуулна.	I-IV улирал		25-30 оюутанд тэтгэлгийг олгосон байна.	ГХХАГ ДМББУЗГ БЗС СХОГ
		Гадаадын зээл тусlamжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, болон түүний хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулна.	I-IV улирал		Цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулсан байна.	ГХХАГ
14.	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох;	Төслийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.	I-IV улирал		Засгийн газрын тусгай тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	ШУИТБЗГ ШУТСан

		<p>Тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.</p>	I-IV улирал		<p>Засгийн газрын тусгай тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p>	ШУИТБЗГ	ШУТСан
15.	4.1.3.4.төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах;	<p>Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгана.</p>	I-IV улирал		<p>Төсвийн төсөлд орон нутгийн саналыг тусгасан байна.</p>	СХОГ	СХ

Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

16.	4.1.4.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх;	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендэрийн баримт бичиг, тендэр шалгаруулалтг явуулах журам, тендэрийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулна.	I-IV улирал	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, сонирхогч этгээдийг танилцах боломжоор хангах аргах хэмжээг авч ажиллана.	XOX	БЕГ
	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулна.	I-IV улирал	Худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдсан байна.	XOX	БЕГ	

		Тендэрийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухай салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх арга хэмжээ авна.	I-IV улирал		Үнэлгээний хороонд хувийн хэвшил, ТББ-ын төлөөллийг оролцуулсан байна.	XOX	БЕГ
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр							
17.	4.1.7.1.төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас	Боловсруулан гаргахаар төлөвлөж буй хууль тогтоомжийн төсөлд холбогдох ТББ, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар арга хэмжээ зохион байгуулна.	I-IV улирал		Хуулийн төсөл, дүрэм, журам боловсруулахад Төрийн бус байгууллага, олон нийтийн оролцох оролцоог нэмэгдүүлсэн байна.	XЭЗХ	ТБББНБТГ, ШУТБИХХЗГ, ЕББЗГ, ДМББУЗГ, ХШУДАГ, СӨБХ, ХЭЗХ, ЦБСХ, СХҮҮХ

	урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих;	Боловсруулж буй хуулийн төсөл, нийтээр дагаж мөрөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана.	I-IV улирал		Иргэд олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	XЭЗХ	БНБТГ, ШУТБИХХЗГ, ЕББЗГ, ДМББУЗГ, ХШУДАГ, ХЭЗХ, ЦБСХ, СХҮҮХ
--	--	---	-------------	--	--	------	---

Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

18.	4.1.10.3.зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах;	Хүмүүжлийн зерэг арга хандлагыг төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах, харилцан туршлага солилцено.	I-IV улирал		Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж буй хүүхэд залууст сургалт зохион байгуулагдсан байна.	ЕББЗГ, ДМББУЗГ, БЕГ	АТГ, ХЭЗХ, БЕГ Харья байгууллагын удирдах албан тушаалтан
		Насан туршдаа суралцахуйн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.	I-IV улирал		Насан туршдаа суралцахуйн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулж хэлэлцүүлсэн байна.	БНБТГ	ЕББЗГ, ДМББУЗГ, СӨБХ

		Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилна. /цахим хуудас, сургалт сурталчилгаа, мэдээ, мэдээллийн самбар, гарын авлага тараах, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт/	I-IV улирал		Авлигын эсрэг хууль тогтоомжийг салбарын хэмжээнд сурталчлах ажлыг яамны албан хаагчид болон харьяа байгууллага бүр зохион байгуулж үр дүнгийн талаарх тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	ТЗУГ	АТГ, Хууль эрх зүйн хэлтэс, Харьяа байгууллагууд
19.	4.1.10.4.авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	Судлаачдын ёс зүй, эрдэм шинжилгээний байгууллагын соёлыг дээшлүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, авлигаас ангид байлгах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	I-IV улирал		Судлаачийн ёс зүй, эрдэм шинжилгээний байгууллагын соёлыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн нөлөөлийн ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.	ДМББУЗГ, ШУТБИХХЗГ	АТГ, ХЭЗХ, Шинжлэх ухааны академи

		<p>Багшийн мэргэжлийн ёс зүй, сургалтын байгууллагын соёлыг дээшлүүлэх нийгмийг соён гэгээрүүлэхэд боловсролын салбарын ажилтны үүрэг, оролцоо зэрэг сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, авлигаас ангид байлгах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулна.</p>	I-IV улирал		<p>Багш, ажилтнуудад сургалт зохион байгуулагдсан байна.</p>		<p>ДМББУЗГ, ЕББЗГ, СӨБХ</p>	<p>АТГ, ХЭЗХ Харьяа байгууллагууд</p>
--	--	--	-------------	--	--	--	-------------------------------------	---

---ooOoo---